Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

# КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА, МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АУДИТ, ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН БАЯРАА ОВОГТОЙ УНДРАЛЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| Зорилт 1. “Кибер аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийг зохицуулах” | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1 Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий болон төрийн захиргааны төв байгууллагатай мэдээлэл солилцох, хамтран ажиллах журмыг холбогдох байгууллагатай хамтран батлуулах | Батлагдсан журмын тоо | - | 1 | “Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий болон төрийн захиргааны төв байгууллагатай мэдээлэл солилцох, хамтран ажиллах журам”-ыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд, Тагнуулын Ерөнхий газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн А/57, А/76 дугаар хамтарсан тушаалаар батлуулж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 6887 дугаартай бүртгэгдсэн. | 01-06 | 100 |
| 2. | Арга хэмжээ 1.2 “Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх этгээдийг бүртгэх, аудит хийх журам”-ын хэрэгжилтийг хангуулах | Аудит хийх эрхтэй хуулийн этгээдэд хяналт хийсэн тоо | - | 2 | 1.Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх этгээдийг бүртгэх, аудит хийх журмын 3 дугаар зүйлийн 3.10.Бүртгэх байгууллага аудит хийх зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн энэ журмын 3.2-т заасан шаардлагыг | 06, 12 | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хангаж байгаа эсэхэд хагас жил тутамд хяналт хийнэ. гэж заасны дагуу Салбарын улсын байцаагчийн 2024 оны 07 дугаар сарын 08-ний өдрийн 09-00/09 дугаар тушаалаар Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын удирдамжийг батлуулсан. Тус удирдамжид заасны дагуу Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх зөвшөөрөл авсан 26 хуулийн этгээдэд 2024 оны 08 дугаар сарын 20-ны өдрөөс 08 дугаар сарын 30-ны өдрүүдэд Салбарын хяналтын газартай хамтран Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийсэн.<br>2.Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх этгээдийг бүртгэх, аудит хийх журмын 3 дугаар зүйлийн 3.10.Бүртгэх байгууллага аудит хийх зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн энэ журмын 3.2-т заасан шаардлагыг хангаж байгаа эсэхэд хагас жил тутамд хяналт хийнэ. гэж заасны дагуу Салбарын улсын байцаагчийн 2024 оны 12 дугаар сарын 05-ний өдрийн 17 дугаар тушаалаар Хяналт шалгалтын удирдамжийг батлуулж, хяналт шалгалт хийн хугацааг 2025 оны 02 дугаар сард зохион байгуулахаар тусгасан. | | |
| 3. | | Бүртгэж, зөвшөөрөл олгосон хуулийн этгээдийн тоо | 18 | 8 | Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх зөвшөөрөл авахаар 29 байгууллагаас хүсэлт ирүүлснийг Төрийн нарийн бичгийн даргын А/170 | 01-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тушаалаар байгуулагдсан байнгын ажлын хэсгээр магадлан шалгаж, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын тушаалаар 25 байгууллагад зөвшөөрөл олгож, 4 байгууллага материалын шаардлага хангаагүй шалтгаанаар зөвшөөрөл олгохоос татгалзсан.<br>Мөн мэдээллийн аюулгүй байдлын аудит, кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийлгэж хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах тухай 2024 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 03/61 дугаартай албан бичгийг 150 байгууллагад, 2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 03/844 дугаар албан бичгийг онц чухал, мэдээллийн дэд бүтэцтэй 211 байгууллагад хүргүүлсэн. | | |
| 4. | Арга хэмжээ 1.3<br>“Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх журам, аргачлал”-ыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, хэрэгжилтийг хангуулах | Бүртгүүлсэн баримт бичгийн тоо | - | 1 | “Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх журам, аргачлал”-ыг дахин боловсруулж Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Тагнуулын ерөнхий газрын дарга нарын 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн А/30, А/148 дугаар хамтарсан тушаалаар батлуулж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2024 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 6982 дугаарт бүртгүүлсэн. | 01-03 | 100 |
| 5. | | Бүртгэж, зөвшөөрөл | - | 5 | Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх зөвшөөрөл хүссэн 12 хүсэл ирүүлснийг Төрийн нарийн | 01-12 | 80 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | олгосон хуулийн этгээдийн тоо | | | бичгийн даргын А/170 тушаалаар байгуулагдсан байнгын ажлын хэсгээр магадлан шалгаж, 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын тушаалаар 4 байгууллагад зөвшөөрөл олгосон. Магадлан шалгах ажлын хэсгийн дараагийн хурлыг 2024 оны 12 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. | | |
| Зорилт 2. "Кибер аюулгүй байдлын Зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх" | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 2.1<br>Кибер аюулгүй байдлын зөвлөлөөс гарсан шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулалтаар хангаж ажиллах | Зохион байгуулалтаар хангаж ажилласан эсэх Тийм-1, Үгүй- | - | 1 | Кибер аюулгүй байдлын зөвлөлийн 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 03 дугаар тогтоолоор байгуулагдсан хүний хувийн мэдээлэл хакеруудын хар зах дээр түгээгдэж буйтай холбогдуулан халдлага зөрчилд дүн шинжилгээ хийх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийн удирдамж, төлөвлөгөөний дагуу Эрүүл мэндийн яаманд 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөс 15-ны өдрүүдэд холбогдох шалгалтыг хийж, тайлан гаргасан.<br>Кибер аюулгүй байдлын зөвлөлийн 2 дугаар хурал 2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр зохион байгуулагдсан. Тус хуралдаанаас гарсан шийдвэрийг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. Мөн Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөл, танилцуулгын | 01-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хамт Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. | | |
| 2. | Арга хэмжээ 2.2<br>Кибер аюулгүй байдлын зөвлөлийн бүтэц, дүрэм, үйл ажиллагааны журмын хэрэгжилтийг хангуулах | Хэрэгжилтийг хангуулсан эсэх Тийм-1, Үгүй-0 | - | 1 | Кибер аюулгүй байдлын ажлын албаны өдөр тутмын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн ажилласан. Мөн Ажлын албаны шинэ бүтэц, орон тооны хязгаар болон цалингийн сүлжээг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн А/53 дугаар тушаалаар батлуулсан. | 01-12 | 100 |
| Зорилт 3. Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чадавхыг бий болгох, энэ чиглэлийн үйл ажиллагаатай төвүүдийн хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 3.1<br>Кибер аюулгүй байдал, Мэдээллийн аюулгүй байдлын талаар үндэсний хэмжээний арга хэмжээ зохион байгуулах | Арга хэмжээний тоо | - | 1 | “Кибер тусгаар тогтнол форум”-ыг зохион байгуулах ажлын хэсэгт орж ажилласан. Мөн мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх зөвшөөрөл бүхий хуулийн этгээдүүдтэй уулзалт зохион байгуулж тулгамдаж буй асуудал болон форумын үеэр өөрсдийн байгууллагын үйл ажиллагааг сурталчлах боломжтой талаар мэдээлэл хүргэсэн.<br>“Кибер тусгаар тогтнол форум” нь 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр 3 салбар хуралдаантайгаар зохион байгуулагдсан ба Салбар хуралдаан хоёр – “Кибер аюулгүй байдлын өнөөгийн нөхцөл байдал, кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ болон мэдээллийн аюулгүй байдал” сэдэвт хэлэлцүүлэгт оролцсон. | 10-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2. | Арга хэмжээ 3.2<br>Кибер халдлага зөрчлийн дадлага, сургуулилт зохион байгуулах | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | - | 2 | 1.Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Зэвсэгт хүчний Жанжин штабын Кибер аюулгүй байдлын цэргийн командлалтай хамтран 2024 оны 01 дүгээр сарын 12-ноос 13-ны өдрүүдэд Кибер халдлага зөрчилд хариу үзүүлэх “ITACTIC” команд штабын хамтарсан сургуулилтыг Зэвсэгт хүчний Сургалтын нэгдсэн төвд зохион байгуулсан. Арга хэмжээнд кибер аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий 7 байгууллагын 80 алба хаагч хамрагдаж, кибер халдлага, зөрчлийн үед хэрхэн хариу арга хэмжээ авах талаар бодит байдлын сургуулилт хийж, гарсан үр дүнд тулгуурлан байгууллага хооронд санал солилцсон.<br>Кибер халдлага зөрчилд хариу үзүүлэх “ITACTIC-2” команд штабын хамтарсан сургуулилтыг 2024 оны 12 дугаар сарын 12-ноос 13-ны өдрүүдэд кибер аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагуудын төлөөллийг оролцуулан зохион байгуулахаар бэлтгэл хангаж ажиллаж байна.<br>2.Кибер аюулгүй байдлын систем хөгжүүлэгч Trend Micro компанитай хамтран 2024 оны 11 дүгээр сарын 18-аас 22-ны өдрүүдэд “Аюулаас хамгаалах ахисан түвшний сургалт”-ыг зохион байгуулж, Кибер халдлага зөрчилтэй тэмцэх Нийтийн төв УТҮГ | 01, 12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | болон Үндэсний төвийн нийт 10 албан хаагчийг хамруулсан. Сургалтаар халдлагын төрөл, хэрхэн халдлагыг илрүүлэх, таслан зогсоох, хариу арга хэмжээ авах талаар сургалт орж, хийсвэр орчинд үүсгэсэн машинд үүсгэсэн даалгавруудыг даалгаврын дагуу гүйцэтгэсэн. Мөн сургалтад хамрагдаж буй албан хаагчдыг 2 багт хуваан Final challenge-ийн амжилттай хийж дуусгасан. | | |
| Зорилт 4. "Кибер аюулгүй байдлыг хангах чиглэлийнх үйл ажиллагаатай олон улсын болон гадаад улсын байгууллагатай хамтран ажиллах" | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 4.1<br>Кибер аюулгүй байдлыг хангах чиглэлийн үйл ажиллагаатай олон улсын болон гадаад улсын байгууллагатай хамтын ажиллагааг эхлүүлэх | Хамтын ажиллагаа эхлүүлсэн байгууллагын тоо | - | 1 | Япон улсын компьютерын ослын эсрэг багийн зохицуулах төв (JPCERT/CC) болон Монгол Улсын Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв хооронд байгуулах харилцан ойлголцлын санамж бичгийн төслийг боловсруулж, JPCERT/CC болон Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага ЖАЙКА-д хүргүүлэн санал авч, санамж бичигт тусган хариу хүргүүлээд байна. | 01-12 | 80 |
| 2. | Арга хэмжээ 4.2<br>Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх үйл ажиллагаа бүхий олон улсын байгууллагуудад өөрийн орныг гишүүнээр элсүүлэх | Гишүүнээр элссэн байгууллагын тоо | - | 1 | Литва Улсын NRD компани болон Цахим аюулгүй байдлын мэдээлэл, удирдлагын төв (MNCERT/CC) нарын дэмжлэгтэйгээр Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх Нийтийн төв УТҮГ-ыг 2024 оны 06 дугаар сарын 14-ний өдөр Олон улсын кибер аюулгүй байдлын байгууллага "FIRST"-д гишүүнээр элсүүлсэн. Мөн Мэдээллийн аюулгүй байдал, | 07-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | нэвтрэлтийн тест, цахим шүүх шинжилгээний чиглэлээр ажилладаг Америкийн олон улсын компани “OffSec”-д гишүүнээр элссэн. | | |
| Зорилт 5. “Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах” | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 5.1<br>Хууль тогтоомж болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн хүрээнд ТЖАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг холбогдох журмын дагуу боловсруулж батлуулах, тайлагнана. | ТЖАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний тоо,<br>ТЖАХ-ийн гүйцэтгэлийн биелэлтийн тоо | - | ТЖАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний тоо – 1<br>ТЖАХ-ийн гүйцэтгэлийн биелэлтийн тоо – 1 | Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг холбогдох журам, аргачлалын дагуу боловсруулж, нэгжийн удирдлагаар батлуулж, батлагдсан загварын дагуу биелэлтийг хагас болон бүтэн жилээр тайлагнасан. | 01-12 | 100 |
| 2. | Арга хэмжээ 5.2<br>Тушаал шийдвэр цаг үеийн болон бусад асуудлаар удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангах, өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж ажиллана. | Үүрэг даалгаврыг хугацаанд нь гүйцэтгэсэн эсэх | - | Үүрэг даалгаврыг хугацаанд нь гүйцэтгэж, эргэн тайлагнасан байна. | Тушаал шийдвэр цаг үеийн болон бусад асуудлаар удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангах, өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэн ажилласан. | 01-12 | 100 |
| 3. | Арга хэмжээ 5.3<br>Чиг үүргийн дагуу бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт болон шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гарган, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлнэ. | Холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлсэн эсэх | - | Хэрэгжилтээр | Чиг үүргийн дагуу бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт болон шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гарган, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэн ажилласан. | 01-12 | 100 |
| 4. | Арга хэмжээ 5.4 | Хууль болон холбогдох | - | Хэрэгжилтээр | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон холбогдох журам, | 01-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон холбогдох журам, стандартад нийцүүлэн баримт бичгийн төсөл төлөвлөх, архивын нэгж бүрдүүлнэ. | журамд нийцүүлэн баримт бичгийн төсөл төлөвлөж, архивын нэгж үүсгэсэн эсэх | | | стандартад нийцүүлэн баримт бичгийн төсөл боловсруулан ажилласан. | | |
| 5. | Арга хэмжээ 5.5<br>Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, холбогдох журамд заасны дагуу цохогдсон өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хугацаанд нь шийдвэрлэн ажиллана. | Өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хугацаанд нь шийдвэрлэсэн тоо | - | Хэрэгжилтээр | Тайлант хугацаанд иргэдээс тоон гарын үсэгтэй холбоотой 1 хүсэлт, 1 санал, хүний хувийн мэдээлэлтэй холбоотой 1 хүсэлт, мэдээллийн аюулгүй байдалтай холбоотой 1 гомдол ирүүлснээс ирүүлснээс 2 хүсэлт, 1 саналыг шийдвэрлэсэн.<br>Иргэнээс ирүүлсэн гомдол нь Цагдаагийн байгууллагад хэрэг бүртгэлт үүсэн хяналтын шатандаа явж байна. | 01-12 | 85 |
| 6. | Арга хэмжээ 5.6<br>Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг мөрдөх хэрэгжилтийг хангаж ажиллана. | Хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд мэдүүлэх<br>Ашиг сонирхлын мэдүүлгийн тоо | - | ХАСХОМэдүүлэг – 1<br>Ашиг сонирхлын мэдүүлгийн тоо-хэрэгжилтээр | Тайлант хугацаанд Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг тус тус хугацаанд нь мэдүүлж, баталгааны маягтыг баталгаажуулж Эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсэн. | 01-12 | 100 |

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1.<br>Үндэсний хэмжээний кибер халдлагаас хамгаалах төлөвлөгөөг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэх | Хүргүүлсэн төлөвлөгөөний тоо | - | 1 | Үндэсний хэмжээний кибер халдлагаас хамгаалах төлөвлөгөөний төслийг Тагнуулын ерөнхий газартай хамтран төлөвлөгөөний төслийг хамтран боловсруулж, 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагуудын төлөөллүүдийг хамруулсан олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулсан. | 01-04 | 70 |
| 2. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3.<br>Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хуульд нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хэсэгт ажиллах | Ажлын хэсэгт ажилласан эсэх<br>Тийм-1<br>Үгүй-0 | - | 1 | Зөвшөөрлийн тухай хуулийн хуулийн хэрэгжилтийг хангах, хуульд нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хүрээнд Монголын үндэсний худалдаа аж, үйлдвэрийн танхим, Улсын их хурлын гишүүн Х.Ганхуягийн ажлын алба, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тус салбараас олгож байгаа тусгай болон энгийн зөвшөөрлийн мэдээллийг гарган хүргүүлсэн. Мөн 2024 оны 12 дугаар сарын 11-ний өдөр Улсын их хурлын гишүүн Х.Ганхуягийн ахалсан ажлын хэсгийн хуралд оролцсон. | 10-12 | 100 |

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Арга хэмжээ 1.<br>Чиг үүргийн хүрээнд сургалтад хамрагдах | Сургалтын тоо | - | 1 | Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага ЖАЙКА-гаас зохион байгуулсан “Кибер аюулгүй байдлын төлөвлөлтийн | 01 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | загвар стандарт 2024" ээлжит семинарт 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр хамрагдсан. | | |
| 2. | | | | | Америкийн нэгдсэн улсын MITRE байгууллагаас зохион байгуулсан "Ransomware" халдлагад "NIST CSF Profile" болон тэргүүлэх аргачлалыг ашиглах нь сэдэвт сургалтад 2024 оны 04 дүгээр сарын 02-ноос 04-ний өдрүүдэд хамрагдсан. | 04 | 100 |
| 3. | Арга хэмжээ 2.<br>Гадаад орны ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагын сургалтад хамрагдах | Сургалтын тоо | - | 1 | Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-аас Япон Улсын Токио хотноо 2024 оны 05 дугаар сарын 19-ний өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдрүүдэд зохион байгуулах "Кибер халдлагаас хамгаалах дадлага" сэдэвт сургалтад хамрагдаж | 05-06 | 100 |
| 4. | Арга хэмжээ 3.<br>Мэлгэшил дээшлүүлэх сургалтад хамрагдах | Сургалтын тоо | - | 1 | Харилцаа Холбоо Мэдээллийн Технологийн салбарын мэргэжилтэнд<br>мэргэшлийн зэрэг олгох сургалтад хамрагдсан. | 11- 12 | 100 |

ТАЙЛАН ГАРГАСАН:

Ахлах мэргэжилтэн ............................... /Б.Ундрал/ ......... ......... .........

( Албан тушаал ) ( Нэр, гарын үсэг ) ( Огноо )